

Эх дээр ажиллах хэсгийг засах зөвлөмж

Даалгаврын дугаар	Оноо өгөх зөвлөмж	оноо	нийт оноо
1	Өгөгдсөн үйл явдал болсон шалтгааныг эхлэл хэсгээс зөв олж бичсэн бол	2	2
	Шалтгааныг өөрийн үгээр тайлбарлан бичсэн бол	1	
	Шалтгааныг буруу бичсэн бол	0	
2	Эхийн үйл явдал ямар улиралд болсныг зөв бичсэн бол	1	3
	Ямар улиралд болсныг буруу бичсэн бол	0	
	Ямар улиралд болсныг батлах жишээ эхээс хоёрыг олж бичсэн бол	2	
	Ямар улиралд болсныг батлах жишээ эхээс нэгийг олж бичсэн бол	1	
	Эхээс жишээ татан бичээгүй бол	0	
3	Эхээс өгөгдсөн баатрын хэлсэн үг, хийсэн үйлийг ялган бичсэн бол	2	4
	Баатрын хэлсэн үг, хийсэн үйлдлийг аль нэгийг бичсэн бол	1	
	Эхээс олж бичээгүй бол	0	
	Хийсэн үйл, хэлсэн үгийг үндэслэн баатрын зан чанар, сайн, муу үйлийг тодорхойлж, дүгнэж бичсэн бол	2	
	Хийсэн үйл, хэлсэн үгийг үндэслээгүй өөрийн үгээр баатрын зан чанар, сайн, муу үйлийг тодорхойлж, дүгнэж бичсэн бол	1	
	Асуултад хамааралгүй хариулт бичсэн бол	0	
4	Баатрын зан чанарын өөрчлөлтийг эхлэл, төгсгөл хэсгээр харьцуулан бичээд, өөрчлөгдсөн шалтгааныг бичсэн бол	3	3
	Баатрын зан чанарын өөрчлөлтийг эхлэл, төгсгөл хэсгээр харьцуулан бичээд, өөрчлөгдсөн шалтгааныг бичээгүй бол	2	
	Баатрын зан чанарын өөрчлөлтийг эхлэл, төгсгөл хэсгээр харьцуулан бичээгүй ч , өөрчлөгдсөн шалтгааныг бичсэн бол	1	
	Баатрын зан чанарын өөрчлөлтийг эхлэл, төгсгөл хэсгийн аль нэгийг бичсэн бол	1	
	Асуултад хамааралгүй хариулт бичсэн бол	0	
5	Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг оновчтой сонгож бичээд, өөрийн үгээр тайлбарласан бол	3	3
	Эхийн төгсгөл хэсгээс гол санааг илэрхийлсэн өгүүлбэрийг оновчтой сонгож бичээд, тайлбарлаагүй бол	2	
	Эхийн гол санааг өөрийн үгээр тайлбарлан бичсэн бол	1	
	Асуултад хамааралгүй хариулт бичсэн бол	0	

Зохион найруулан бичих засах зөвлөмж

№	Үнэлгээний шалгуур	Авбал зохих оноо	Онооны задаргаа
1	Сэдэв ба зорилго	3	<p>3 оноо: - Тухайн өгөгдсөн сэдвийн дагуу утгаа зөв ойлгож, зорилгоо бүрэн хангаж бичсэн тохиолдолд</p> <p>2 оноо: - Бичих сэдэв, зорилгоо дутуу гаргаж бичсэн тохиолдолд</p> <p>1 оноо: - Бичих сэдэв, зорилгоо хагас дутуу гаргаж бичсэн тохиолдолд</p> <p>0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд</p> <p>х: - юу ч бичээгүй тохиолд</p>
2	Бүтэц	3	<p>3 оноо: - Тухайн бичвэрийн бүтцийн хувьд эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй бичсэн тохиолдолд</p> <p>2 оноо: - Бүтцийн аль нэг хэсгийг дутуу бичсэн тохиолдолд</p> <p>1 оноо: - Бүтэц илт дутуу бичсэн тохиолдолд</p> <p>0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд</p> <p>х - юу ч бичээгүй тохиолдолд</p>
3	Үг сонголт	2	<p>2 оноо: - Сэдвийн хүрээнд үгийг чөлөөтэй сонгож, зөв хэрэглэсэн тохиолдолд</p> <p>1 оноо: - Сэдвийн хүрээнд зарим үгийг оновчгүй сонгож, үг давтаж хэрэглэсэн тохиолдолд</p> <p>0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд</p> <p>х - Юу ч бичээгүй тохиолдолд</p>
4	Зөв бичгийн дүрмийн алдаа	5	<p>5 оноо: - Огт алдаагүй буюу 1 алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>4 оноо: - 2-4 үгийг алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>3 оноо: - 5-7 үгийг алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>2 оноо: - 8-10 үгийг алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>1 оноо: - 11-14 үгийг алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>0 оноо: - 15-аас дээш үг алдаатай бичсэн тохиолдолд</p> <p>х - юу ч бичээгүй тохиолдолд</p>
5	Бичгийн хэв	2	<p>2 оноо: - Зөв сайхан гаргацтай, хичээнгүй бичсэн бол</p> <p>1 оноо: - Зөв хичээнгүй бичээгүй ч уншиж болж байвал</p> <p>0 оноо: - Үнэлэх боломжгүй тохиолдолд</p> <p>х - юу ч бичээгүй тохиолдолд</p>
Нийт оноо		15	